

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРААС  
2018 ОНЫ 10 ДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**


2018 оны 10 дугаар сарын 30

Улаанбаатар хот

Тус газар нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2018 оны 09 дүгээр сарын 26-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрийн хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

**НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

**1.1. Виз, зөвшөөрлийн чиглэлээр:**



Тайлангийн хугацаанд “Монгол Улсад оршин суух үнэмлэх” 2044 ширхгийг шинээр хэвлэн, 1756 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 7 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийлээ. Түүнчлэн үйлчилгээний зааланд нийт 2160 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч, визийн зөвшөөрөл, хувийн урилга олгох үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх програм хангамжийн хүрээнд 22 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлж, 2 аж ахуйн нэгж, байгууллагын 2 гадаадын иргэний визийн зөвшөөрлийн хүсэлтийг холбогдох хууль, журмын дагуу хянан шийдвэрлэлээ.

2018 оны 10 дугаар сарын тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 7.8 хувиар, хувийн урилга олголт 54.5 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 1.9 хувиар өсөж, виз олголт 9.5 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 17.7 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 44.5 хувиар тус тус буурсан байна.

1.2. Иргэний харьяалал, хүүхэд үрчлэлт, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын 28 иргэн, харьяалалгүй 4 хүн болон Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан гадаадын 6 иргэний баримт бичиг хянагдаж байна.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын 8 иргэн, харьяалалгүй 2 хүний баримт бичгийг хянан Цагдаагийн Ерөнхий газарт дахин санал авахаар хүргүүлж, гадаадын 1 иргэн, харьяалалгүй 1 хүнтэй байгууллагын даргын 2016 оны А/65 дугаар тушаалаар баталсан “Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргагчтай ярилцлага хийх журам”-ын дагуу ярилцлага хийлээ.

Мөн Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан харьяалалгүй 1 хүний хүсэлтийг хянан холбогдох байгууллагаас санал авч, дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, гадаадын 3 иргэн, харьяалалгүй 1 хүний хүсэлтийг хянан холбогдох байгууллагаас санал авч, дүгнэлт үйлдэн Ерөнхий сайдад танилцуулснаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барихаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлсэн.

Монгол Улсын харьяатаас гарч бусад 4 улсын харьяат болох хүсэлт гаргасан 32 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч холбогдох ажиллагааг эхлүүллээ.

Монгол Улсын харьяатаас гарах хүсэлт гаргасан 50 иргэний баримт бичгийг хянан холбогдох санал авахаар Улсын бүртгэлийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газарт, 4 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч, дүгнэлт боловсруулан Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, 57 иргэний хүсэлтэд санал авч, дүгнэлт боловсруулан Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулснаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барихаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлсэн.

Иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй 3 хүний баримт бичгийг хянан холбогдох байгууллагын саналыг авснаар Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 138, 139 дүгээр зарлигаар Монгол Улсын харьяатаас гарсан 49 иргэний мэдээллийг бүртгэн, мэдээллийн санд оруулах, Гадаад харилцааны яамны Консулын газар, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргүүлэх ажлыг зохион байгууллаа.

Түүнчлэн хоёрдмол харьяалал үүсгэсэн 145 иргэнийг бүртгэж, мэдээллийн санд оруулсан байна.

Тайлант хугацаанд олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах 2 хүсэлт, шинээр нээх 1 хүсэлтийг хүлээн авсан.

Мөн гадаадын 3 улсын гэр бүлд үрчлүүлсэн 9 хүүхдийн үрчлэлтийн дараах тайланг хүлээн авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн.

1.3. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Тайлангийн хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2, 37.1.3, 37.1.7, 37.1.12 дахь заалтуудыг тус тус үндэслэн 11 улсын 61 иргэнийг байгууллагын даргын 15 удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргаж, 1 улсын 2 иргэний албадан гаргасан шийдвэрийг хугацаанаас өмнө цуцалсан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Мөн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 2 улсын 6 иргэнийг байгууллагын даргын 5 удаагийн тушаалаар Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, 1 улсын 2 иргэнийг байгууллагын даргын 2 удаагийн тушаалаар гарахыг түдгэлзүүлснийг хүчингүй болгож, хилээр нэвтрэх эрхийг сэргээсэн байна.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэл, Монгол Улсаас албадан гаргасан гадаадын иргэдийн мэдээллийг 2 удаагийн албан бичгээр хүргүүлсэн.

Монгол Улсаас хилийн чанадад суугаа Элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газар, Консулын газар, Өргөмжит консулаас визийн хүчинтэй хугацаа буруу, нэрийн үсэг дутуу, визийн зориулалт бичигдээгүй нийт 40 иргэнд олгогдсон визийг тухай бүр хуулбарлан авч, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын виз олгох журамд заасны дагуу шинээр виз олгон хил нэвтрүүлсэн болно.

Монгол Улсад орох визгүй болон ирсэн зорилгодоо нийцсэн зохих ангиллын визгүй нийт гадаадын 73 иргэнийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2010 оны 338 дугаар тогтоолд заасны дагуу тус тус орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан ба гарах-орох визгүй, виз авах байгууллагын албан хүсэлтгүй, оршин суух зөвшөөрөлд хасалт хийлгэх албан бичиггүй зэрэг үндэслэлээр гадаадын 16 иргэнийг гарах чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан. Мөн Монгол Улсад визгүй зорчигч гадаадын иргэн, хөдөлмөр эрхлэх магадлалтай 22 орны 173 иргэнтэй ярилцлага хийж, 3 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас баталгаа гаргуулан баримт бичгийг хуулбарлан хилээр гарсан байдалд хяналт тавьж бүртгэл хөтөллөө.

Албадан гаргагдсан гадаадын иргэдийн мэдээлэл:

№	Улс	ГИЭЗБТХ-ийн зүйлчлэл				Нийт
		37.1.2	37.1.3	37.1.7	37.1.11	
1	АНУ	-	1	-	1	2
2	Австрали	-	-	-	1	1
3	БНКазУ	1	-	-	1	2
4	БНСВУ	1	-	-	-	1
5	БНХАУ	-	2	40	2	44
6	Израиль	-	-	-	1	1
7	ОХУ	-	-	-	5	5
8	СанМарино	-	-	-	1	1
9	Сенегал	-	-	-	1	1
10	Словак	-	-	-	1	1
11	ХБННУ	-	-	-	2	2
Нийт		2	3	40	16	61

Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн 1 захирамжаар гадаадын 1 иргэнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн дэргэдэх гадаадын иргэнийг саатуулах байранд саатуулж, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасан үндэслэлээр 4 улсын 7 иргэнд гарах сануулга өгсөн.

Тайлангийн хугацаанд 7 удаагийн төлөвлөгөөт, 19 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 84 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 854 иргэнийг хамруулсан бөгөөд гадаадын 300 иргэн, 162 аж ахуйн нэгж, байгууллага /гадаадын 594 иргэн/, 12 уригч иргэн /гадаадын 12 иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 169,480,000 /нэг зуун жаран есөн сая дөрвөн зуун наян мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээ.

## ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

### 2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажлын чиглэлээр:

Засгийн газрын “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 2017 оны 01 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ний холбогдох хэсгийн 2018 оны 3 дугаар улирлын байдлаарх биелэлтийг Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдад, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай байгууллагын даргын байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээний 2018 оны 3 дугаар улирлын хэрэгжилт, “Хариуцлагын жил болгох тухай” Засгийн газрын 2018 оны 32 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний холбогдох хэсгийн 2018 оны 3 дугаар улирлын байдлаарх биелэлт, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын холбогдох хэсгийн биелэлт, байгууллагын 2018 оны 09 дүгээр сарын байдлаарх үйл ажиллагааны тоон мэдээг инфографик хэлбэрээр гарган Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид, “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу холбогдох хэсгийн тайлан, байгууллагын 2018 оны 09 дүгээр сарын үйл ажиллагааны тайланг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт, “Дэлхийн Монголчууд” хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний холбогдох хэсгийн хэрэгжилт болон 2019 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд тусгах саналыг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргад, “Хууль сахиулах салбарын инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 2018 оны ажлын төлөвлөгөөний холбогдох хэсгийн 2018 оны 3 дугаар улирлын биелэлтийг Хууль сахиулахын их сургуулийн эрдэм шинжилгээ эрхэлсэн тэргүүн дэд захиралд, Байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2018 оны 3 дугаар улирлын төлөвлөгөөний биелэлт, Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2018 оны 3 дугаар улирлын төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд албан бичгээр тус тус хүргүүлж ажиллалаа.

Байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу дэд даргаар ахлуулсан ажлын хэсэг Баруун бүс дэх газарт 10 дугаар сарын 04-өөс 14-ний өдрүүдэд ажиллаж тус газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өглөө.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 76 өргөдөл ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 54 өргөдөл шийдвэрлэгдэж, 22 өргөдөл хуульд заасан хугацааны хүрээнд шийдвэрлэлтийн шатандаа байгаа ба хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй байна.

Тайлант хугацаанд олон нийттэй харилцах чиглэлээр 9 мэдээ бэлтгэж олон нийтэд хүргэсэн бөгөөд тус мэдээллүүд 4 телевиз, 13 сайтад нийтлэгдсэн байна. Монголын үндэсний олон нийтийн телевизээр 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр цацагдах “Бүх нийтийн эрх зүйн боловсролд” шууд нэвтрүүлгээр “Монгол Улсын иргэний харьяаллын асуудал, Гадаадын төрийн бус байгууллагын бүртгэл хяналт” сэдэвтэй холбогдуулан уг нэвтрүүлэгт ашиглагдах тоо баримт, тодорхой мэдээллүүдийг бэлтгэлээ. Мөн Монголын үндэсний олон нийтийн телевизийн “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлгийн 2 дугаарыг бэлтгэхтэй холбогдуулан “Гадаадын иргэдийн хяналт шалгалт”, “Гадаадын иргэнд Монгол Улсын виз олгох журам, Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журмын хэрэгжилт” сэдвээр тус нэвтрүүлэгт ашиглагдах дүрс, эх сурвалжийн яриа зэргийг нэгтгэн, “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлгийн найруулагчид хүргүүлсэн.

Архив, албан хэрэг хөтлөлтөд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийн 4 дэх шатны зорилтын хүрээнд 2016-2017 оны байнга хадгалах баримтаас нийт 30 хадгаламжийн нэгжийг цахим хэлбэрт шилжүүлээд байна. Түүнчлэн байгууллагын даргын 2017 оны А/37 дугаар тушаалын дагуу цаасан суурьтай баримтыг тоон хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд цахимжуулах 2017 оны түр хадгалах 1072 хадгаламжийн нэгжээс 100 хадгаламжийн нэгж бүхий 25000 хуудас баримтыг сканерт оруулж, эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийлээ.

2018 оны 09 дүгээр сарын 28, 10 дугаар сарын 03-ны өдөр Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний дагуу гамшиг ослын үед хэрхэн ажиллах талаар Аюулгүй байдал хариуцсан ахлах мэргэжилтэн болон Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал унтраах 30 дугаар ангийн салааны захирагч, ахлах дэслэгч н.Мөнхсайхан ирж холбогдох албан хаагчдад гамшгаас хамгаалах дадлага, сургууль бэлэн байдлын үзлэгтэй холбоотой зааварчилгаа өгөв.

Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын ажил, мэргэшлийн ерөнхий мэдлэг, ур чадварын түвшинг тогтоох шалгалтыг 10 дугаар сарын 13-ны өдөр байгууллагын төрийн захиргааны албан хаагчдаас тестийн програм дээр хууль, эрх зүйн 50, англи хэлний 10, компьютерийн мэдлэг шалгах 5 тест, эссэ бичлэг, албан бичиг, тушаал, шийдвэрийн төсөл боловсруулалт гэсэн даалгаврын хүрээнд зохион байгуулж нийт 170 албан хаагч хамрагдлаа. Мөн 10 дугаар сарын 24-ний өдөр төрийн үйлчилгээний албан хаагчдаас холбогдох хууль, эрх зүй, хөдөлмөрийн дотоод журам, ажил үйлчилгээний стандартын хүрээнд 50 асуулттай тестийн шалгалтыг зохион байгуулж нийт 41 албан хаагч хамрагдсан бөгөөд шалгалтын нийт дүнг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

## 2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

“Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай” хуулийн төсөлд тусгах саналыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан “Дэлхийн Монголчууд” хөтөлбөрийн Зөвлөлийн бүрэлдэхүүний төсөлд өгөх саналыг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргад тус тус хүргүүлсэн.

Тайлангийн хугацаанд тус байгууллагын бүтцийн нэгжид шинээр томилогдохоор нэр дэвшсэн 8 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүллээ.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас Бээжин хотод суугаа Элчин Сайдын Яамны баримт бичиг хариуцсан зөвлөх, холбооны цагдаагийн албаны төлөөлөгч ноён Дирк Малзан, Михаил Гиллихь нарыг урьж байгууллагын албан хаагчдад “Бичиг баримтын нууцлалын үзүүлэлт” сэдвээр сургалт, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Нийгмийг Аюулаас Хамгаалах Тэнхимийн Хилээр орох гарах асуудал хариуцсан товчооны дэд дарга Баян-Эрдэнэ тэргүүтэй төлөөлөгчдийг Улаанбаатар хотноо хүлээн авч, байгууллагын үйл ажиллагаатай танилцуулах айлчлалыг тус тус зохион байгуулсан.

Мөн байгууллагын дарга СИТА /SITA/ компанийн Хойд Ази, Номхон далайн бүс нутаг хариуцсан Худалдааны төлөөлөгч Софи Юнг, Монгол Улс дахь төлөөлөгч Ц.Галсандорж нартай уулзалт хийж Засгийн газрын 2018 оны 306 дугаар тогтоолтой холбогдуулан Зорчигчийн урьдчилсан мэдээллийн дэвшилтэт систем /APP/-г нэвтрүүлэх талаар танилцуулж, цаашдын хамтын ажиллагааны талаар хэлэлцлээ.

### 2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн үүргийн дагуу байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны статистик мэдээллийг оруулах програмын хөгжүүлэлтийг хийж Үндэсний дата төвөөс өгөгдлийн сан руу хандах нэр, нууц үгийг авлаа. Сүлжээний 5 инженерийг ажлын 10 хоногийн хугацаатай Гадаадын иргэдийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем /ISM/-ийн мэргэшүүлэх сургалтад хамруулсан.

### 2.4. Дүн шинжилгээ, дотоод аудит, зөвлөгөө мэдээллийн чиглэлээр:

Байгууллагын 2018 оны 3 дугаар улирлын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу 2018 оны 3 дугаар улирлын байдлаарх Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд болон Баруун бүс дэх газрын 2017, 2018 оны санхүүгийн тайланд төсөв, санхүүгийн аудитын шалгалтыг зохион байгуулж, шалгалтын явцад алдаа, дутагдал анхаарах асуудлын талаар зөвлөгөө, мэдээлэл өгөн төсөв, санхүүгийн дотоод аудитын чиглэлээр 8 төрлийн сорилыг хийж гүйцэтгэн ажиллалаа.

Тайлант хугацаанд нийт 2783 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар нийт 1777, биечлэн 1006 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. Үүнээс виз, визийн зөвшөөрлийн талаар утсаар 771, биечлэн 514, Монгол улсад албан болон хувийн хэргээр оршин суух зөвшөөрөл олгох, сунгах, хасах талаар утсаар 475, биечлэн 454, бусад асуудлаар утсаар 531, биечлэн 38 иргэнд тус тус зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

### 2.5. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн ажлын талаар:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2018 оны төсөв 6,4 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд өссөн дүнгээр 09 дүгээр сарын байдлаар нийт 5,6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдож зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцууллаа.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 2018 оны 10 дугаар сарын байдлаар өссөн дүнгээр 2,7 тэрбум төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 339 сая төгрөгийн хүү торгуулийн орлого, 150 сая төгрөгийн визний хуудасны орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна.

Хилийн боомт, орон нутаг дахь газарт ажиллаж байгаа албан хаагчдад өвлийн гутал, хүрэмний хангалтыг “Цагаан шонхор” ТӨУҮГ-аас хүлээн авч хийлээ.

### 2.6. Боомт, орон нутгийн чиглэлээр:

Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төслийн 2, 3 дугаар бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэх судалгааны ажлын хүрээнд мэдээлэл, холбооны технологийн олон улсын зөвлөлтэй, мөн төслийн хүрээнд хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулах зорилгоор Алтанбулаг, Сүхбаатар, Гашуунсухайт боомтын авто зам, барилга байгууламжийг шинэчлэх зураг төслийг гүйцэтгэгч аж ахуйн нэгжтэй тус тус уулзалт зохион байгуулсан.